

## ХИЧЭЭЛ 12

УНШИХ ЗҮЙЛ: ЛУК 2:15-20; МАТАЙ 2:1,10,11; ДАГАЛДАГЧДЫН ҮЙЛС, Х. 48, 59-67.

# Хамгийн Сайхан Бэлэг

Та нарын авч байсан хамгийн сайхан бэлэг чинь юу вэ? Та нар баяртай байсан уу? Та нар Есүсийн тухай бодохдоо үүн шиг баярладаг уу? Тэр та нарын хамгийн сайхан бэлэг мөн үү?



**М**

арь өвөр дээр нь унтаж байгаа хүүгээ ширтэн сууна. Дараа нь Иосеф руу харав.

"Тэр минь ямар төгс юм бэ?" хэмээн дуу алдлаа. "Хүү минь төгс сайхан."

Иосеф ч мөн хариу инээмсэглэв. Бяцхан Есүс ашгүй нэг мэндэлсэн байна. Бурхан тэдэнд түүнийг өгсөн юм. Иосеф бараг итгэж чадахгүй байлаа. Тэрээр доош тонгойгоод хүүгийн бяцхан гарыг хоёр гараараа барьж үзжээ.

Аав ээжүүд бүгдээрээ үр хүүхдээрээ бахархдаг. Тэдний хувьд хүүхдүүд нь маш чухал. Гэхдээ хүү нь үнэхээр хэн бүхнээс онцгой нэгэн гэдгийг Марь, Иосеф хоёр сайн мэдэж байсан юм. Хэдийгээр тэр малын хашаанд мэндэлсэн боловч тэрээр Бурханы хүү байсан юм. Бурхан үнэлж баршгүй зүйлээ хайрлуулж халамжлуулахаар Марь, Иосеф хоёрыг сонгожээ.


Иосеф ард нь ямар нэг зүйл чимээ гарахыг сонсов.

### Цээжлэх Ишлэл:

"Өнөөдөр... Аврагч  
Эзэн мэндэллээ"  
ЛУК 2:1.

### Тол Санаа:

Есүс бол Бурханы  
бидэнд өгсөн  
хамгийн сайхан  
бэлэг.



Хоньчид хаалгаар зөөлөн алхсаар орж иржээ. Тэд өлмий дээрээ гишгэлсээр өвсөн дээр хэвтэж байсан Марь, Иосеф хоёрыг зүглэн алхав. "Бид жаал хүүг харахаар ирлээ" гэж тэд тайлбарлажээ. "Энэ шөнө Аврагч Эзэн маань мэндэллээ гэж тэнгэр элч нар бидэнд хэлсэн юм."

"Тэнгэр элч нар гэнээ?" хэмээн Марь лавлав. "Тэнгэр элч нар?"

Хоньчид Марь, Иосеф хоёрт үзсэн зүйлээ тайлбарлан яриу. Тэд өмнө хэзээ ч харж байгаагүй сүр жавхлантай зүйлийг харжээ. Гайхамшигтай сайхан дуу хөгжим сонссоноо ярьлаа. Хоньчид малын саравчинд удтал саатсан юм. Тэнгэр элчийн үгэнд итгэсэн гэдгээ ч тэд хэлэв. Энэ

хүү бол Бурханы Хүү гэдгийг тэд мэдэж байсан

юм. Тэд тэндээс явахыг хүсэхгүй л байлаа.

Харин дараа нь Иосеф, Марь хоёрыг малын саравчнаас гарч жижигхэн байшинд ороод байж байтал үүдэн дээр нь хэдэн харийн хүмүүс хүрч иржээ. Тэд нэгэн онцгой одыг маш алс холоос олон өдөр даган явсаар энд хүрч ирсэн байна. Од явсаар Есүс дээр тэднийг хөтлөн аваачихыг тэд мэдэж байсан юм. Од явсаар энэ жижиг байшингийн дээр ирж зогссон байжээ. Тэдний зарц нарынх нь нэг нь хаалгыг нь тогшив. Тог, тог.

Хаалга нээгдэн, Иосеф гарч ирлээ. Тэрээр хаалгаа нээтэл олон тэмээ, зарц нартай, тансаг хувцасласан аяны хүмүүс тэдний гадаа иржээ. Энэ мэргэн хүмүүс алс холын орноос ирсэн байна. "Та нар дотогш орооч" хэмээн Иосеф гайхан дуу алджээ. "Гэрт орцгоогооч."

Мэргэн хүмүүс дотогш орлоо. Хүүгээ тэврэн сандал дээр чимээгүйхэн суух Марийг тэд олж харав. Мэргэн хүмүүс бяцхан Есүсийн өмнө сөгдөн хүндэтгэл үзүүлжээ. Дараа нь тэд жаал хүүд зориулж авчирсан бэлэг сэлтээ Марь, Иосеф хоёрт гардууллаа. Есүсийг бэлэг болгон өгсөнд нь тэд Бурханыг магтан хүндэтгэсэн байна. Тэд Бурханд бэлэг өгч, хайраа харуулан алдаршуулсан юм.

Марь, Иосеф хоёр инээмсэглэв. Бурхан үнэхээр тэдэнд агуу гайхамшигт бэлэг-хүн төрөлхтний Аврагчийг өгсөн юм.

# Дасгал Ажил

## ШАББАТ

Энэ долоо хоногийн өдөр бүр Библийн түүхийг уншиж, цээжилсэн ишлэлийг нь хамтдаа давтаарай.

**Өнөөдөр ... Аврагч** .....Дээшээ заах.


**Эзэн мэндэллээ.** .....Жаахан хүүхэд тэврэх мэт гараа бүүвэйлэх.

**Лук 2:1** .....Алгаа нийлүүлээд дэлгэнэ.

## НЯМ

Шаббат хичээл дээр хийсэн одоо хэн нэгэнтэй хуваалцаж мөн түүнд бяцхан Есүс мэндэлсэн тухай ярихад нь хүүгээ урамшуулаарай.

(Эсвэл од зураад түүнийгээ хайчилж аваад хүүгээрээ чимэглүүлээрэй. Дээд талд нь нүх гаргаад утсаар уяарай.)



## ДАВАА

Лук 2:8-20 болон Матай 2:1,2,10,11-г хамтдаа уншаарай. Асуух: Бяцхан Есүсийн байсан малын саравчин дотор ямар үнэртэй байсан гэж та нар бодож байна? Есүсийг харах гэж хэн хүрч ирсэн бэ? Түүнийг хараад тэдэнд ямар сэтгэгдэл төрсөн гэж та нар бодож байна? Есүс яах гэж энэ дэлхийд ирсэн бэ?

Хүүхдээ хоньчин болгож жүжиглүүлээд зориулан бэлдсэн газар руу Есүсийг харуулахаар гүйлгээрэй.

## МЯТМАР

Хэдэн Мэргэн хүн Есүс дээр хүрч ирж хичнээн бэлэг сэлт өгснийг хэлж тоолуулаарай. Асуух: Тэд ямар бэлэг өгсөн бэ? (алт г.м.) Энэ бэлэгнүүдийн хэр

зэрэг үнэтэй болохыг ярилцаарай. Хүүхдэдээ ямар нэг үнэртэн үнэртүүлж үзнэ үү.

"Их Эзэн Жаал Хүү" (Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, No. 141) дууг хамтдаа дуулаад Есүсийн төлөө Бурханд талархаарай.

## ЛХАТВА

Шөнө гадаа гарч тэнгэрийн оддыг хараарай.

Асуух: Мэргэн хүмүүсийн дагаж байсан од ямар харагдаж байсан гэж чи бодож байна? Хэзээ хүмүүс тэнгэрт олон тэнгэр элч нарыг харах вэ? (Есүсийг эргэж ирэхэд)

## ПҮРЭВ

Есүсийн мэндэлсэн өдрийг тэмдэглэн жижиг бялуун дээр хэдэн лаа асаагаарай. Эсвэл булочкан дээр асаагаарай. Энэ нь Есүс бол Бурханы бидэнд өгсөн хамгийн сайхан бэлэг гэдгийг сануулах зорилготой. Асуух: Бид зул сарын баяраар яагаад хүмүүст бэлэг өгдөг вэ?



## БААСАН

Гэрийхнийгээ хувцаслаад, Библийн түүхийг жүжиглэж тоглоорой. (хүрэм, алчуур г.м.) Алчуур дэвссэн хайрцгийг тэвш болгон ашиглаарай. Дотор нь хүүхэлдэй хийж тавиарай. Асуух: Та нар Есүст ямар бэлэг өгөх вэ?

Зарим задлаагүй бэлгийг үзэцгээгээрэй. Асуух: Бурханы бидэнд өгсөн хамгийн сайхан бэлэг юу вэ? (Есүс) Есүс яагаад энэ дэлхийд ирсэн бэ?

Есүс мэндэлсэн тухай дуу дуулаад, дараа нь гэр бүлийн тань төлөө амиа өгсөнд нь Түүнд талархаарай.